



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/138/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

do dd. 02. 25 № *2/27*

Г БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ Г
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ЖАВЗАНСҮРЭН ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

• 005020785

D:\Alban bichig\A4-toot.docx

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,381,104.11</u>	<u>47,699,152.65</u>
33	АВЛАГА	1,600,000.00	00.00
335	Бусад авлага	1,600,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,600,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,781,104.11	47,699,152.65
351	Түүхий эд материал	8,881,230.00	4,897,230.00
35110	Тусгай зориулалттай материал	8,881,230.00	4,897,230.00
354	Хангамжийн материал	37,899,874.11	42,801,922.65
35410	Бичиг хэргийн материал	1,257,820.00	1,733,620.00
35420	Аж ахуйн материал	8,428,554.11	18,450,154.11
35430	Сэлбэг хэрэгсэл	100,000.00	1,005,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,082,648.54
35450	Барилгын засварын материал	1,005,500.00	1,005,500.00
35470	Бусад хангамжийн материал	27,108,000.00	18,525,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,699,315,225.83</u>	<u>1,717,553,231.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,699,315,225.83	1,717,553,231.58
392	Биет хөрөнгө	1,637,898,225.83	1,656,292,231.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,332,434,922.00	1,415,934,922.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-208,315,945.95	-271,526,747.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,004,800.00	352,054,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-93,334,071.83	-127,368,365.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	262,489,674.00	295,962,409.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-127,079,361.20	-162,144,866.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,901,021.13	56,304,681.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,397,145.85	-32,397,797.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	212,972,400.00	212,972,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-71,578,066.47	-89,299,203.90
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,800,000.00	5,800,000.00
393	Биет бус хөрөнгө	61,417,000.00	61,261,000.00
39301	Програм хангамж	780,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-117,000.00	-273,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60,754,000.00	60,754,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,747,696,329.94</u>	<u>1,765,252,384.23</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,158,855.00</u>	<u>18,700,970.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,158,855.00	18,700,970.00
413	Өглөг	15,158,855.00	18,700,970.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	15,158,855.00	18,700,970.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,732,537,474.94</u>	<u>1,746,551,414.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,732,537,474.94	1,746,551,414.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	525,709,281.22	525,709,281.22
51101	Өмч: - төрийн	525,709,281.22	525,709,281.22
512	Хуримтлагдсан үр дүн	893,816,151.92	919,267,458.39
51210	Өмнөх үеийн үр дүн	893,816,151.92	905,253,519.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	14,013,939.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	313,012,041.80	301,574,674.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,747,696,329.94</u>	<u>1,765,252,384.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	686,761,140.11	696,837,686.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,505,674.11	266,601,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	236,505,674.11	266,601,730.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	236,505,674.11	340,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	340,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	235,845,674.11	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	00.00	226,290,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	00.00	39,971,130.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	450,255,466.00	430,235,956.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,895,366.00	17,508,745.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,665,000.00	7,024,942.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,230,366.00	10,483,803.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380360100.00	412622900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,360,100.00	412,622,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	104,311.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	104,311.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	556,403,329.71	632,915,177.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	556,403,329.71	632,915,177.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,334,420.12	631,215,258.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,511,039.00	229,487,309.40
210101	Үндсэн цалин	228,511,039.00	229,487,309.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,341,999.09	29,949,954.87
210201	Тэтгэврийн даатгал	19,766,457.65	21,611,773.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,402,609.01	2,202,594.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,806,175.00	1,762,074.11
210204	Ажилгүйдлийн даатгал	395,609.43	397,592.89
210205	Эрүүл мэндийн даатгал	3,971,148.00	3,975,919.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,736,286.58	43,631,496.11
210301	Гэрэл, цахилгаан	5,446,831.58	8,070,881.11
210302	Түлш, халаалт	32,289,455.00	35,560,615.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,452,863.00	59,084,789.46
210401	Бичиг хэрэг	2,858,680.00	6,506,700.00
210402	Тээвэр, шатахуун	33,863,103.00	40,997,339.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,343,200.00	509,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	5,550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,267,880.00	5,521,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,864,500.00	831,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,290,500.00	831,000.00
210604	Урсгал засвар	574,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	4,142,000.00	4,290,000.00
210702	Дотоод албан томилолт	4,142,000.00	4,290,000.00

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,383,233.00	24,689,198.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,930,693.00	20,729,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	342,900.00	525,690.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	488,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	524,800.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,979,000.00	2,684,000.00
210807	Газрын төлбөр	305,840.00	228,384.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,902,499.45	239,251,510.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,915,700.00	78,058,485.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,544,999.45	161,193,025.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,068,909.59	1,699,919.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	1,354,311.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	1,354,311.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,564,028.81	344,933.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,564,028.81	344,933.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,604,880.78	675.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,604,880.78	675.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	130,357,810.40	63,922,508.31
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,149,007.95	49,908,569.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	49,908,569.02
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,149,007.95	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,149,007.95	-49,908,569.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	120,208,802.45	14,013,939.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	450,915,466.00	432,175,956.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	660,000.00	340,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	660,000.00	340,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,000.00	340,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	340,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	450,255,466.00	431,835,956.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,895,366.00	19,108,745.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,665,000.00	7,024,942.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,230,366.00	12,083,803.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	380,360,100.00	412,622,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380,360,100.00	412,622,900.00

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	104,311.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	104,311.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	450,915,466.00	429,126,956.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,915,466.00	429,126,956.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,846,556.41	427,427,036.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,243,610.51	223,818,789.90
210101	Үндсэн цалин	223,243,610.51	223,818,789.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,980,688.32	29,722,829.37
210201	Тэтгэврийн даатгал	19,035,392.36	20,769,238.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,236,399.00	2,238,499.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,788,999.85	1,790,698.45
210204	Ажилгүйдлийн даатгал	447,198.85	447,699.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,472,698.26	4,476,693.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,429,992.36	39,725,881.11
210301	Гэрэл, цахилгаан	4,935,892.36	8,070,881.11
210302	Түлш, халаалт	17,494,100.00	31,655,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,093,340.00	47,445,467.00
210401	Бичиг хэрэг	4,118,440.00	4,557,800.00
210402	Тээвэр, шатахуун	30,586,600.00	33,069,367.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,183,500.00	863,300.00
210404	Ном, хэвлэл	00.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	5,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	844,800.00	2,905,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,855,000.00	1,736,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,475,000.00	1,736,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	180,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	4,142,000.00	4,290,000.00
210702	Дотоод албан томилолт	4,142,000.00	4,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,338,725.22	22,843,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,325,735.22	18,916,970.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	595,350.00	558,690.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	495,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,603,800.00	2,604,000.00
210807	Газрын төлбөр	305,840.00	228,384.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,763,200.00	57,845,025.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,063,200.00	57,845,025.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,068,909.59	1,699,919.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	1,354,311.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	104,311.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	1,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,564,028.81	344,933.62

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,564,028.81	344,933.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,604,880.78	675.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,604,880.78	675.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	3,049,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,049,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,049,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,049,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,049,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,049,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,709,281.22	313,012,041.80	893,816,151.92	00.00	1,732,537,474.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,709,281.22	313,012,041.80	893,816,151.92	00.00	1,732,537,474.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,709,281.22	313,012,041.80	893,816,151.92	00.00	1,732,537,474.94
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,709,281.22	313,012,041.80	893,816,151.92	00.00	1,732,537,474.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	11,437,367.18	00.00	11,437,367.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,709,281.22	313,012,041.80	905,253,519.10	00.00	1,743,974,842.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-11,437,367.18	00.00	00.00	-11,437,367.18
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,013,939.29	00.00	14,013,939.29
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,709,281.22	301,574,674.62	919,267,458.39	00.00	1,746,551,414.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,622,800.00	412,617,966.38	1,004,833.62	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,622,800.00	412,617,966.38	1,004,833.62	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,622,800.00	411,617,966.38	1,004,833.62	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,837,000.00	223,818,789.90	18,210.10	100.0
210101	Үндсэн цалин	223,837,000.00	223,818,789.90	18,210.10	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,950,800.00	29,722,829.37	227,970.63	99.2
210201	Тэтгэврийн даатгал	20,997,300.00	20,769,238.32	228,061.68	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,238,500.00	2,238,499.82	0.18	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,790,700.00	1,790,698.45	1.55	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	447,700.00	447,699.51	0.49	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,476,700.00	4,476,693.27	6.73	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,754,900.00	39,725,881.11	29,018.89	99.9
210301	Гэрэл, цахилгаан	9,600,000.00	8,070,881.11	1,529,118.89	84.1
210302	Түлш, халаалт	30,154,900.00	31,655,000.00	(1,500,100.00)	105.0
2104	Хангамж, бараа материалын зардал	47,666,100.00	47,445,467.00	220,633.00	99.5
210401	Бичиг хэрэг	4,461,000.00	4,557,800.00	(96,800.00)	102.2
210402	Тээвэр, шатахуун	33,260,000.00	33,069,367.00	190,633.00	99.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	882,800.00	863,300.00	19,500.00	97.8
210404	Ном, хэвлэл	250,000.00	300,000.00	(50,000.00)	120.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,907,300.00	5,750,000.00	157,300.00	97.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,905,000.00	2,905,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,405,000.00	3,405,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,405,000.00	3,405,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,700,000.00	4,540,000.00	160,000.00	96.6
210702	Дотоод албан томилолт	4,700,000.00	4,540,000.00	160,000.00	96.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,309,000.00	5,114,974.00	194,026.00	96.3

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,188,900.00	11,100.00	99.1
210803	Даатгалын үйлчилгээ	590,000.00	558,690.00	31,310.00	94.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,000.00	495,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	40,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,604,000.00	2,604,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	380,000.00	228,384.00	151,616.00	60.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,000,000.00	57,845,025.00	154,975.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,000,000.00	57,845,025.00	154,975.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	413,622,900.00	412,617,966.38	1,004,933.62	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	412,622,900.00	412,277,966.38	344,933.62	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	412,622,900.00	412,277,966.38	344,933.62	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	340,000.00	660,000.00	34.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	340,000.00	660,000.00	34.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	07.00	07.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,895,366.00	19,108,070.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,895,366.00	19,108,070.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,895,366.00	19,108,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,895,366.00	19,108,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,895,366.00	19,108,070.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,895,366.00	19,108,070.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр ирүүлсэн байна.

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга М.Жавзансүрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Алимаа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилго: Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ард иргэдэд төрийн үйлчилгээг байнгын тасралтгүй үзүүлж, шударга ёсыг эрхэмлэн дээдлэхэд оршино.

Чиг үүрэг: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийн хэрэгжүүлнэ. Төр,эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

- Ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, сумын боловсон хүчний судалгааг бусад төрийн байгууллагуудтай хамтран гаргаж, нутгийн уугуул боловсон хүчнийг ажиллуулах талаар судлах.
- Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон болох
- Төрийн чиг үүргийг иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, сэтгэл ханамжтай хүргэхэд оршино

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чгг үүргийг хэрэгжүүлдэг ба Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 556,403.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,564.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,894.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,430.4 мянган төгрөг байгаа тул төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,556.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,381.1	47,699.2	(682.0)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,600.0	-	(1,600.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	46,781.1	47,699.2	918.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,699,315.2	1,717,553.2	18,238.0
Үндсэн хөрөнгө	2,232,136.8	2,400,563.2	168,426.4
Хуримтлагдсан элэгдэл	(532,821.6)	(683,010.0)	(150,188.4)
Нийт хөрөнгө	1,747,696.3	1,765,252.4	17,556.1
Өр төлбөр	15,158.9	18,701.0	3,542.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,732,537.5	1,746,551.4	14,013.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,747,696.3	1,765,252.4	17,556.1

Өмнөх онд авлагын данс 1,600.0 мянган төгрөг байсан бол тайлант онд үлдэгдэлгүй болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47,699.2 мянган төгрөг болж 918.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 10,021.6 мянга, түлш шатах тослох материал 2,082.6 мянга, сэлбэг хэрэгсэл 905.0 мянга, бичиг хэргийн материал 475.8 мянган төгрөгөөр өсөж, тусгай зориулалтын материал 3,984.0 мянга, бусад хангамжийн материал 8,583.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,400,553.2 мянган төгрөг болж 168,426.4 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын 2021 оны 115 тоот тогтоолоор Малын гарал үүслийн гэрчилгээний системд зориулан 6,741.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер болон принтер үнэ төлбөргүй өгсөн, мөн сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр тогтоолоор 13,649.9 мянга, 2021 оны 32 дугаар тогтоолоор 207,449.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө бүртгэх шийдвэрээр хөрөнгө орлогод бүртгэсэнтэй холбоотой байна. Тайлант онд аймгийн ИТХ-ын 08, 137 тоот тогтоолуудаар 56,823.2 мянган төгрөгийн хөрөнгө, Сумын ИТХ-ын 21 дүгээр тогтоолоор 4,090.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 18,701.0 мянган төгрөг болж өмнөх оноос 3,542.1 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын зардлын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,765,252.4 мянган төгрөг болж 14,013.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347,717.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,986.1 мянган төгрөгөөр бууруулж 353,703.1 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 413,622.9 мянга мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 412,622.9 мянга, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 412,622.9 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогоор 340.0 мянган төгрөгийг оруулж, 412,618.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 344.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 412.618.0 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардал 18.2 мянга, ЭМНДШ-ийн зардал 227.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 29.0 мянга, томилолтын зардал 160.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 771.7 мянга, аймгийн ЗДТГ-аас өвс тээвэрлэлтийн зардалд 1,262.7 мянга, ухаалаг худгийн усны төлбөрт 941.6 мянга, ЗГ-аас усны үнийн хөнгөлөлтөд 1,049.0 мянга, сумын төсвийн төсөвт байгууллагаас хог усны төлбөр, хашааны үнэ 2,159.0 мянга, Хаан банкнаас хог усны төлбөрт 210.0 мянган төгрөг, хамтарсан багийн зардалд 300.0 мянга, өвсний орлогоор 2,160.0 мянга, иргэдээс түрээсийн орлогоор 750.0 мянга, бусад орлогоор 1,983.8 мянган төгрөг нийт 19,108.7 мянган төгрөг төвлөрч 19,108.1 мянган төгрөгийн зарцуулан оны эцэст 0.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Төрийн захиргааны албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж улирал тутамд дүгнүүлэн ажилласан. Засаг даргын тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 бүлэг 56 заалттай баталж жилийн эцсийн байдлаар 94.5%-тай хэрэгжсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 632,915.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 76,511.9 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос өссөн бол бусад зардлууд буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 489,913.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 489,913.9 мянган төгрөгийн 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв.

Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	3	1	0
4	Сар бүр	3	36	35	1	0
5	Тухай бүр	8	96	83	13	0
6	Нийт	27	151	132	17	2

3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 413,622.9 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 412,618.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,004.9 мянган төгрөг буюу 0.3 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 4,700.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,540.0 мянган төгрөг зарцуулж 160.0 мянган төгрөг хэмнэжээ.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 39,754.9 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 39,725.9 мянган төгрөг зарцуулж, анх

баталсан дүнгээс 29.0 мянган төгрөг буюу 0.1 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд ЕБС-ын хүнс, болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,000.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгасан талаар сумын ЗДТГ-ын даргын 2021 оны 106 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,622.9 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөрчил давтан гаргахгүй байх, таслан зогсоох зөвлөмж хүргүүлэв.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны эхэнд түлш, халаалтын зардлын өглөг 14,795.4 мянган төгрөгийн өртэй байсан бөгөөд тайлант оны эцэст 18,701.0 мянган төгрөгийн өртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 489,913.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 489,913.9 мянган төгрөгийн 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 39,754.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 39,725.9 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8¹

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

дахь заалтаар 20 хувь буюу 7,951.0 мянган төгрөг хэмнэхээс 29.0 мянган төгрөг буюу 0.1 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Овоо сумын ЗДТГ	3	26,622.9	0	0	0	0	0	0	3	26,622.9

_____оОо_____